


ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

07.13 - 07.17



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд харьцангуй холимог үзүүлэлттэй хаагдсан байна. S&P500 индекс дараалан 3 долоо хоног өсөлт үзүүлж, 2-р сарын сүүл үеэс хойших хамгийн өндөр цэгтээ хүрсэн байна. Харин хөрөнгө оруулагчид зах зээлийн үнэлгээ ихтэй өсөлтийн хувьцаанаас (higher-valuation growth shares) илүүтэйгээр үнэ цэнтэй хувьцаа (value stocks) сонирхох болсноор технологийн компаниудыг илүүтэйгээр агуулдаг Nasdaq Composite индекс бууралттай байлаа. S&P500 индексийн сагсанд багтах аж үйлдвэрлэлийн салбарын компаниудын хувьцаа хамгийн их өсөлттэй байсан бол технологийн салбарын компаниудын хувьцаа хамгийн их уналттай байлаа.

Refinitiv агентлагийн мэдээлснээр S&P500-ийн 32 компани энэ долоо хоногт хоёрдугаар улирлын үйл ажиллагааны тайлангаа гаргахаар товлосон байна. Томоохон банкнууд чанаргүй зээлийн хэмжээ ойрын хугацаанд нэмэгдэнэ гэсэн хүлээлттэй байгаа ба үүнтэй холбоотой эрсдэлийн сангаа нэмэгдүүлсэн нь ашигт ажиллагааны үзүүлэлтүүдийг бууруулсан ч андеррайтингийн болон арилжааны орлого өсөлттэй гарсан байна.

Европ: Коронавирусийн эсрэг вакцин хөгжүүлэлт ахицтай байгаатай холбоотой Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй байлаа. STOXX Europe 600 индекс 1.6%-аар, DAX индекс 2.26%-аар, CAC 40 индекс 1.99%-аар, FTSE MIB индекс 3.24%-аар, FTSE 100 индекс 3%-аар тус тус өссөн байна.

Баасан гарагт Европын Холбооны удирдагчид хоёр хоног үргэлжлэх дээд хэмжээний уулзалт эхлүүлж, Евро бүсийн орнуудад яаралтай туслах 750 тэрбум еврогийн эдийн засгийг дэмжих хөтөлбөрийн тухай хэлэлцэж байгаа ба зуны сүүлчээс өмнө зөвшилцөлд хүрнэ гэж найдаж байна. Хамгийн их санал зөрөлдөж байгаа сэдвүүд нь нөөц сангийн хэмжээ, хуваарилалтын шалгуур мөн зээл болон тусламжийн харьцаа зэрэг асуудлууд байгаа юм. Нидерланд, Швед, Дани болон Австри улсуудын хувьд үйлдвэрлэл болон ажил эрхлэлтийг дэмжих шинэчлэлүүдэд зээл хэлбэрээр тусламж олгохыг дэмжиж байна. Харин Итали болон Испани буюу корона вирусийн халдварт хүндхэн цохиулаад байгаа орнууд буцалтгүй тусламж авахыг илүүд үзэж байна.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдсан байна. Nikkei 225 Stock Average индекс 406 пункт буюу 1.82% өсөлт үзүүлж 22,696.42 болсон ч өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 4.1%-аар бага байгаа юм. Мөн Япон улсын хөрөнгийн зах зээлийг ерөнхийд нь илтгэгч TOPIX индексүүд өсөлттэй байлаа. Баасан гарагийн байдлаар 1 ам.доллар 107 иентэй тэнцүү байна.

БНХАУ: БНХАУ-ын эдийн засгийн үзүүлэлтүүд суларч байгаа болон АНУ-ын зүгээс худалдааны хурцадмал байдал үүсгээд байгаа тус улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд унахад нөлөөлжээ. Томоохон компаниудын CSI 300 индекс хоёрдугаар сараас хойш анх удаа 4.4% уналттай байсан бол Shanghai Composite индекс 5.0% буураад байна. Хятадын 10 жилийн хугацаатай бондын өгөөж энэ долоо хоногт 9 пунктээр буурч 3.04% болсон байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,543.86	0.71% ▲
Dow Jones	АНУ	26,671.95	2.29% ▲
S&P 500	АНУ	3,224.73	1.25% ▲
Nasdaq	АНУ	10,503.19	-1.08% ▼
S&P/TSX	Канад	16,123.48	2.61% ▲
FTSE 100	Их Британи	6,290.30	3.20% ▲
S&P/ASX 200	Австрали	6,033.60	1.93% ▲
Nikkei 225	Япон	22,696.42	1.82% ▲
Hang Seng	Хонг Конг	25,089.17	-2.48% ▼

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	109.31
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	100.74
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	100.15
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	104.36
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	100.77
DBM' 2023	USD	7.250%	101.27
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	90.08

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.180	0.03 ▲
Libor 3M	0.271	0.01 ▲
Libor 6M	0.334	-0.03 ▼
Libor 1YR	0.470	-0.02 ▼
US 2YR Bond	0.143	-0.13 ▼
US 3YR Bond	0.172	-0.12 ▼
US 5YR Bond	0.276	-0.10 ▼
US 10YR Bond	0.618	-0.04 ▼

Валютын ханш	2020.07.17	Өөрчлөлт
USD	2,834.50	0.08% ▲
CNY	404.91	0.20% ▲
EUR	3,228.78	1.07% ▲
RUB	39.49	-0.85% ▼
KRW	2.35	-0.42% ▼
JPY	26.46	-0.19% ▼
CAD	2,086.95	0.29% ▲

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,810.42	0.65% ▲
Мөнгө /спот/	USD/t oz.	19.33	3.24% ▲
Зэс	USD/lb.	290.45	0.24% ▲
Нүүрс	USD/MT	54.27	0.54% ▲
WTI газрын тос	USD/bbl.	40.59	0.10% ▲
Brent газрын тос	USD/bbl.	43.14	-0.23% ▼
Байгалийн хий	USD/MMBtu	1.72	-4.97% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020.V	3.30%
Бодлогын хүү	2020.V	9.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020.V	8.93%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020.V	11.20%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020.V	4.48%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020.V	17.06%
Зээлийн дундаж хүү /валют/	2020.V	10.41%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg


МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 23 компанийн 70.3 сая төгрөгийн 287,312 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Ард кредит ББСБ” /MSE: ADB/ компанийн хувьцаа 18.12%-аар буюу хамгийн ихээр өсөж 71.00 төгрөг хүрч хаагдсан бол “Ариг гал” /MSE: EER/ компанийн хувьцаа 13.33%-аар буурч 2,600.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.

7-р сарын 17-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,508.2 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,543.86 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.71%-аар өссөн байна.



Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	70.29	
Зах зээлийн үнэлгээ	2,508,150.18	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,543.86	0.71% ▲
MSE I индекс	7,944.61	0.01% ▲
MSE II индекс	7,469.57	1.21% ▲

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Инвекор ББСБ	9,107	22,913,640
Эрдэнэ ресурс девелопмент корп	28,629	21,522,098
Ард кредит ББСБ	58,902	4,097,247
Түмэн шувуут	28,646	3,946,996
Сүү	17,252	3,540,088

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Ард кредит ББСБ	71.00	18.12% ▲
Ард даатгал	750.00	10.29% ▲
Хөх ган	86.90	8.63% ▲
Монгол шуудан	600.00	5.26% ▲
Эрдэнэ ресурс девелопмент корп	770.50	2.73% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Ариг гал	2,600.00	-13.33% ▼
Шарын гол	1,200.00	-7.69% ▼
Цагаантолгой	1,250.00	-7.41% ▼
Тандэм инвест ББСБ	21.50	-5.70% ▼
Говь	190.70	-2.80% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
Ти Ди Би Капитал	41,973,079.60
Ард Секюритиз	33,486,665.05
Бидисек	27,557,805.20
Инвекор Капитал	9,232,900.00
Голомт Капитал	6,079,733.64

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	33Ү (сая.төг)
АПУ	548.40	583,597
Таван толгой	5,530.00	291,239
МИК холдинг	12,990.00	269,014
Инвекор ББСБ	2,515.00	180,396
Говь	190.70	148,767

Компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаа

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТ ХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.05.28-НД ОЛГОВ
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.29-НД ОЛГОВ
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН ББСБ	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НД ОЛГОВ
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.29-НД ОЛГОВ
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,404.8	1,000.0	29.4%	35.0	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.30-НД ОЛГОВ
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХҮНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.04.16-НД ОЛГОВ
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.07.03-НД ОЛГОВ
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.04-НД ОЛГОВ
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.04.17-НД ОЛГОВ
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.29-НД ОЛГОВ
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР
32	TTL	ТАВАН ТОЛГОЙ	48,062.7	43,238.0	90.0%	821.0	2020.04.03	2020.05.31-НИЙ ДОТОР
33	ERS	МОНГОЛ АЛТ	71.3	39.9	55.9%	150.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР
34	TEE	ТЭЭВЭР ДАРХАН	10.9	0.8	749.1%	500.0	2020.04.29	2020.12.31-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ



ОНЦЛОХ МЭДЭЭ

2020 оны 6-р сард “ҮЦТХТ” ХХК нь нийт 11,056 шинэ данс, 2,951 холболтын данс нээсэн байна.

Эдгээрээс 99.9% буюу 11,042 данс нь дотоодын иргэдийн данс байжээ. Харин гадаадын иргэдийн 6 данс, дотоодын аж ахуй нэгжийн 8 данс нээгдсэн бол 2020 оны 6-р сард гадаадын аж ахуй нэгжийн данс нээгдээгүй байна.

Эх сурвалж: Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /MSE: ERDN, TSX: ERD/ ХК хайгуулын мэдээлэл ирүүлээ.

“Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” /MSE: ERDN, TSX: ERD/ ХК (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) өөрийн эзэмшлийн Баян Хөндий Алтны Төслийн (“Төсөл”) баруун өмнөд Страйкер бүсийн өрөмдлөг болон Баян Хөндий алтны ордоос хойд зүгт 3.5 км-т орших шинэ Хар Морь талбайн хайгуулын үр дүнгийн тухай мэдээлэл хүргэж байна.

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли: “2-р улирлын хайгуулын хөтөлбөрөөр шалгасан талбайд гайхалтай үр дүнгүүд гарч, газрын дөт гүнд, өндөр агуулга бүхий огтлолуудыг тодорхойллоо. Өнөөдрийн үр дүн болон бидний саяхан танилцуулсан зүүн өмнөд Мидфийлд бүсийн үр дүнгүүдэд тулгуурлан энэ оны 3-р улиралд Баян Хөндий алтны дүүрэгт нэмэлт өрөмдлөг хийх өндөр агуулга бүхий гурван бүсийг тодорхойлсон.

Баруун өмнөд Страйкер бүсэд 353 г/т алтны агуулга бүхий 1 метр агуулсан 29 г/т алтны агуулга бүхий 15 метрийн интервал огтолсон нь одоогийн Баян Хөндий нөөцөд бага агуулга бүхий материал хэмээн тодорхойлогдсон бүсэд оршиж байгаагаараа онцлог юм. Өнгөрсөн долоо хоногт танилцуулсан зүүн өмнөд Мидфийлд бүсийн 585 г/т алтны агуулга бүхий 1 метрийг багтаасан 126 г/т алтны дундаж агуулга бүхий 5.5 метрийн интервал зэрэг үр дүнгээр Баян Хөндийн бага агуулгатай материалын ангилалд багтсан бүсийн эрдэсжилтийг тэлсэн билээ. Эдгээр өрөмдлөгийн үр дүнгүүд ба 3-р улирлын өрөмдлөгийн үр дүнгээр Баян Хөндийн нөөцийг шинэчлэх боломжтой.”

“Хар Морь талбайн өндөр агуулга бүхий бүсэд хийсэн суваг малталтын үр дүнгээр энэхүү талбай нь Баян Хөндийн нээлтээс хойш тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн томоохон нээлт гэдгийг баталлаа. Бид 3-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрөөрөө энэхүү сонирхолтой шинэ талбайд нарийвчилсан судалгаа хийхээр төлөвлөж байна” хэмээн танилцууллаа.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Лэндмн ББСБ” /MSE: LEND/ ХК шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцож байгаа тухай мэдээлэл.

Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443-р тогтоолоор баталсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам”-ын 3.2-д “Компаниас тухай бүр нийтэд хүргэх мэдээлэлд” дараах мэдээлэл хамаарна гэж заасны дагуу тус журмын 3.2.2.11-д “компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох”-той холбоотой мэдээллийг үүгээр хүргүүлж байна.

“Лэндмн ББСБ” /MSE: LEND/ ХК нь 2020 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар шүүхэд нэхэмжлэгчээр оролцож байгаа тухай мэдээлэл:

№	ТӨРӨЛ	ТОО	ҮНИЙН ДҮН
1	ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН	419	196,650,171 ТӨГРӨГ

Эдгээр нэхэмжлэлүүд нь Анхан шатны шүүхээр хэлэлцэгдэж байгаа бөгөөд эцэслэн шийдвэрлэгдээгүй болно.

“Лэндмн ББСБ” /MSE: LEND/ ХК нь 2020 оны 6-р сарын 30-ны өдрийн байдлаар шүүхэд хариуцагчаар оролцож байгаа тухай мэдээлэл:

№	ТӨРӨЛ	ТОО	ҮНИЙН ДҮН
1	ГЭРЭЭТЭЙ ХОЛБООТОЙ МАРГААН	1	12,500 ТӨГРӨГ

Тус маргаан нь Анхан шатны шүүхээр хэлэлцэгдэж байгаа бөгөөд эцэслэн шийдвэрлэгдээгүй болно.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангаа нийтлэсэн компаниуд.

“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 20-р зүйлийн 20.1.6, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 10-р зүйлийн 10.3 дахь заалтад заасны дагуу Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компани нь жилийн эцсийн болон хагас жилийн санхүүгийн тайлангаа ирүүлэх үүрэгтэй байдаг билээ.

2020 оны 7-р сарын 17-ны байдлаар 29 компани 2020 оны хагас жилийн тайлангаа Монголын Хөрөнгийн Биржид ирүүлсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Энэ 7 хоногт болсон гадаад валютын ээлжит дуудлага худалдаагаар Монголбанк 82.5 сая ам.долларыг валют арилжааны цахим талбарт нийлүүлжээ. Түүний өмнөх 7 хоногт 33.5 сая ам.долларыг мөн нийлүүлсэн юм. Харин своп, форвард арилжаагаар банкууд санал ирүүлээгүй байна.

Эх сурвалж: Montsame.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

Мөнгөний нийлүүлэлт (M2) 2020 оны 6-р сарын эцэст 21.2 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 966.0 (4.8%) тэрбум төгрөгөөр өсөхөд валютын хадгаламж 1.4 (47.1%) их наяд төгрөгөөр, валютын харилцах 105.4 (4.7%) тэрбум төгрөгөөр, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 39.3 (6.0%) тэрбум төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Бага мөнгө (M1) 2020 оны 6-р сарын эцэст 3.6 их наяд төгрөг болж, өмнөх сараас 60.2 (1.7%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 535.6 (13.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Бага мөнгө (M1)-ний 2.9 (80.6%) их наяд төгрөг нь төгрөгийн харилцах, 0.7 (19.4%) их наяд төгрөг нь хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө байна.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ


Монгол Улс 2020 оны эхний хагас жилд нийт 135 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 5.3 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 2.8 тэрбум ам.доллар, импорт 2.5 тэрбум ам.доллар боллоо. Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1.5 тэрбум ам.доллар буюу 22.6%-аар, үүнээс экспорт 1.1 тэрбум ам.доллар буюу 28.2%-аар, импорт 433.7 сая ам.доллар буюу 15.0%-аар тус тус буурчээ. Харин 2020 оны 6-р сард экспорт 822.1 сая ам.доллар, импорт 467.7 сая ам.доллар болж, өмнөх сараас экспорт 189.4 сая ам.доллар буюу 29.9%-аар, импорт 61.6 сая ам.доллар буюу 15.2%-аар тус тус өссөн байна.

Гадаад худалдааны тэнцэл 2019 оны эхний хагас жилд 1.0 тэрбум ам.долларын ашигтай гарч байсан бол 2020 оны эхний хагас жилд өмнөх оны мөн үеэс 677.0 сая ам.доллаароор буурч, 368.2 сая ам.долларын ашигтай байна.

Манай 2 хөрш улс нь гадаад худалдааны нийт эргэлтэд хамгийн өндөр дүнг эзэлж, БНХАУ-тай 3.0 тэрбум ам.долларын худалдааг хийжээ. Энэ нь гадаад худалдааны нийт бараа эргэлтийн 56.2%-ийг эзэлж байна.

БНХАУ-д хийсэн экспорт нь манай улсын нийт экспортын дүнгийн 74.7 хувийг бүрдүүлж байна. БНХАУ-д гаргасан бараа бүтээгдэхүүний 31.2 хувийг чулуун нүүрс, 35.1 хувийг зэсийн баяжмал эзэлж байгаа бол Швейцар улсад экспортолсон

барааны 99.8 хувийг, Сингапур улсад экспортолсон барааны 80.2 хувийг, Их Британи улсад экспортолсон барааны 68.6 хувийг алтны экспорт эзэлж байна.



Экспорт өмнөх оны мөн үеэс 1.1 тэрбум ам.доллаароор буурахад зэсийн баяжмалын экспорт 321.4 сая ам.доллар, нүүрсний экспорт 852.7 сая ам.доллаароор буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

ШИНЖЭЭЧИЙН БУЛАН

2020 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ МЭДЭЭ

2020 оны эхний хагас жилд Монголын Хөрөнгийн Бирж дээр нийт 164,978,464 ширхэг хувьцааг 23,524.1 сая төгрөгөөр, 5,825 ширхэг ЗГҮЦ-ыг 586.9 сая төгрөгөөр, 50,011 мянган ширхэг компанийн бондыг 5,001.1 сая төгрөгөөр тус тус арилжаалсан байна. Нийт арилжааны үнийн дүнгийн 80.81%-ийг хувьцааны арилжаа, 2.02%-ийг ЗГҮЦ-ны арилжаа, 17.18%-ийг компанийн бондын арилжаа эзэлжээ.


Тайлант хугацаанд өдөрт дунджаар 236.7 сая төгрөгийн гүйлгээ хийж, 1.3 сая ширхэг үнэт цаас арилжсан байна.

Хувьцааны арилжаа

Тайлант хугацаанд “Бодь даатгал” /MSE: BODI/ ХК-ийн нийтэд санал болгон гаргасан 47,063,944 ширхэг хувьцааг 5,318.2 сая төгрөгөөр анхдагч зах зээл дээр амжилттай арилжлаа. Хувьцааны анхдагч зах зээлд нийт 5,318.2 сая төгрөгийн арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 22.6% хувийг эзэлж байна.

Хувьцааны хоёрдогч зах зээл дээр нийт 123 удаагийн арилжаагаар 123 компанийн 117,914,520 ширхэг хувьцааг 18,205.8 сая төгрөгөөр арилжсан ба багцын арилжаагаар 8 компанийн 41,694,777 сая ширхэг хувьцаа 3,834.9 сая төгрөгөөр арилжаалагдсан байна.

Хувьцааны хоёрдогч зах зээлийн дээр хамгийн идэвхитэй арилжаалагдсан компаниуд



Хувьцааны хоёрдогч зах зээлийн дээр “Монгол шуудан” /MSE: MNP/ ХК, “Ард санхүүгийн нэгдэл” /MSE: AARD/ ХК, “Монос хүнс” /MSE: MFC/ ХК, “Фронтинер лэнд групп” /MSE: MDR/ ХК “АПУ” /MSE: APU/ ХК, “Лэндмн ББСБ” /MSE: LEND/ ХК, “Хай би ойл” /MSE: HBO/ ХК, “Инвескор ББСБ” /MSE: INV/ ХК, “Ард кредит ББСБ” /MSE: ADB/ ХК болон “Адуун чулуун” /MSE: ADL/ ХК-ийн хувьцаа хамгийн идэвхтэй арилжаалагдсан ба нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 72.28%-ийн эзэлж байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.